ХБНГУ-ЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙД АСАН, ХАТАГТАЙ Х.ДОЙБЛЕР-ГМЕЛИНИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ 2

“ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2023” ӨДӨРЛӨГӨӨР ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЛӨӨ 3

АНУ-ЫН НЬЮ ХЭМПШИР МУЖИЙН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ НАР ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ, САНАЛ СОЛИЛЦЛОО 6

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Баталсан хууль нь хүн бүрт тэгш үйлчилдэг төр л хамгийн тогтвортой оршдог.*

*Аристотель*

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn *Хууль зүйн мэдээллийн сар тутмын цахим сонин* 2023.05.31

## УНШИГЧ ТА БҮХЭНД ХҮҮХДИЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ



## ХБНГУ-ЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙД АСАН, ХАТАГТАЙ Х.ДОЙБЛЕР-ГМЕЛИНИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах, тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор Г.Давааням нар 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр ХБНГУ-ын Хууль зүйн сайд асан Х.Дойблер-Гмелинийг хүлээн авч уулзлаа. Талууд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг сайжруулах хэрэгцээ шаардлага, хууль зүйн салбар дахь хараат бус эрдэм шинжилгээ, судалгааны ач холбогдол, жендерийн тэгш байдал зэрэг олон асуудлын талаар харилцан санал солилцов. Уулзалтад Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Д.Сүнжид, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Улс төр судлалын доктор Э.Саранцэцэг, тус хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Хууль зүйн ухааны



## “БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ”-ЫГ ГОВЬ-АЛТАЙ БОЛОН ХОВД АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг Говь-Алтай , Ховд аймгуудад 2023 оны 05 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Сургалтыг Хууль зүйн ухааны доктор /PhD/, профессор Ц.Цэлмэг, Монголын Хуульчдын холбооны сургагч багш, хууль зүйн ухааны магистр Г.Оюунболд, ХЗҮХ-ийн арга зүйч багш, хууль зүйн ухааны магистр Д.Цэцэгдарь нар зааж, Говь-Алтай аймгийн 58, Ховд аймгийн 30 эрх зүйн хөтөч тус тус хамрагдсан байна.







## “ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2023” ӨДӨРЛӨГӨӨР ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЛӨӨ

Монголын хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Хуульчийн Про Боно өдөр-2023” өдөрлөг Сүхбаатарын талбайд өнөөдөр буюу 05 дугаар сарын 01-ний өдөр боллоо. Тус өдөрлөгт Хууль зүйн үндэсний хүрээлэн оролцож, үйл ажиллагаагаа танилцуулж, үнэ төлбөргүй эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгч ажиллав.

Мөн номын худалдаа болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гаргасан зарим бүтээлийг иргэдэд үнэ төлбөргүй тараалаа.

Иргэн та Даваа-Баасан гарагуудад 08:30-17:30 цаг хүртэл хууль зүйн зөвлөгөө мэдээллийн 1800-1202 утсаар холбогдож зөвлөгөө авах боломжтой.



















Хууль зүйн мэдээ
Улсын бүртгэлийн дугаар 1197
Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэн.
11-315789
www.nli.gov.mn
Бэлтгэсэн Ц.Энхжин

## ХЗҮХ-ЭЭС УЛАМЖЛАЛ БОЛГОН ЗОХИОН БАЙГУУЛДАГ “ДОКТОРЫН ЦУВРАЛ ЛЕКЦ” КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ЯВАГДЛАА







Хууль зүйн үндэсний хүрээлэн нь 2014 оноос эхлэн “Эрх зүй ба хөгжил” сэдвийн хүрээнд магистр, докторуудын шинэ бүтээлийг танилцуулж эхэлсэн ба 2018 оноос эхлэн докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийг танилцуулах, тэдний судалгааны ажлыг нийтийн хүртээл болгох зорилготой “Докторын цуврал лекц”-ийг уламжлал болгон зохион байгуулж ирсэн.

Энэ удаад “Докторын цуврал лекц”-ийг компанийн эрх зүйн хүрээнд зохион байгууллаа.

Зочноор МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш, доктор Б.Оюунжаргал “Монгол улс дахь гүйцэтгэх удирдлагын тогтолцоо” сэдвээр, СЭЗИС-ийн ахлах багш, доктор М.Түвшинжаргал “Компани нэгдэх үйл ажиллагааг арилжааны эрх зүй ба өрсөлдөөний эрх зүйн үүднээс судлах нь” сэдвээр лекц уншиж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Тус арга хэмжээг нээж МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Улаанбаатар, докторын ажил болон лекцийг дүгнэж доктор И.Идэш нар үг хэлж оролцов.

Б.Оюунжаргал, М.Түвшинжаргал докторуудад цаашдын эрдэм шинжилгээний ажилд нь өндөр амжилтыг хүсье!

## ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР Б.ДӨЛГӨӨН “ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙГ ТҮҮНИЙ ШИНЖЭЭР НЬ ЯЛГАН ЗААГЛАХ ОНОЛЫН АСУУДАЛ” СЭДВЭЭР ЛЕКЦ УНШИЖ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙЛЭЭ

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь докторын зэрэг хамгаалсан эрдэмтдийг танилцуулах, тэдний судалгааны ажлыг нийтийн хүртээл болгох зорилготой “Докторын цуврал лекц”-ийг зохион байгуулдаг билээ.

Энэ удаад УДШ-ийн дэргэдэх шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, судалгааны төвийн дарга, Хууль зүйн доктор (Ph.d) Б.Дөлгөөн “Захиргааны зөрчлийг түүний шинжээр нь ялган зааглах онолын асуудал” сэдвээр лекц уншиж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Лекцийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм нарийн бичгийн дарга, Хууль зүйн доктор (Ph.d) Г.Давааням нээж, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, Хууль зүйн доктор (Ph.d) Д.Батболд дүгнэж, хаалтын үг хэлэв.

Доктор Б.Дөлгөөнд эрдэм шинжилгээний ажлын өндөр амжилт хүсье!







## “АЖЛЫН БАЙРНЫ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ-JOB FAIR 2023” АРГА ХЭМЖЭЭНД ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН ОРОЛЦЛОО

Тус хүрээлэнгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4, 4.5, 4.8 дахь хэсэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 2.1.8, 8.1 дүгээр зүйлийн 8.1.3 дахь хэсэг болон Их Засаг Олон Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулиас 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн 01/45 тоот албан хүсэлтийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “АЖЛЫН БАЙРНЫ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ -JOB FAIR 2023” арга хэмжээнд оролцож, хууль тогтоомж болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.legalinfo.mn цахим хуудсыг сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Их Засаг Олон Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн төгсөх курсийн 150 гаруй оюутан хамрагдав.








## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН “ӨМГӨӨЛӨГЧ ТАНД ТУСАЛЪЯ – 2023” ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОЖ ИРГЭДЭД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭВ

Монгол Улсад Өмгөөллийн байгууллага үүсэж хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулж буй хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх зорилготой “Өмгөөлөгч танд тусалъя – 2023” өдөрлөг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатарын талбайд нээлтээ хийлээ.

Тус өдөрлөгт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллийн ажилтнууд оролцож иргэдэд үнэ төлбөргүй хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллав..






## АНУ-ЫН НЬЮ ХЭМПШИР МУЖИЙН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ НАР ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ, САНАЛ СОЛИЛЦЛОО

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн төлөөлөл 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр АНУ-ын Нью Хэмпшир мужийн Дээд шүүхийн ерөнхий шүүгч Гордон Макдональд, Муж улсуудын шүүхийн үндэсний төвийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Майкл Буэнгер болон Муж улсуудын шүүхийн үндэсний төвийн Шүүхийн ёс зүйн төвийн захирал Дэвид Сакар нарыг хүлээн авч уулзлаа,

Тус уулзалтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Даваанлям (LL.D) болон Муж улсуудын шүүхийн Үндэсний төвийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Майкл Буэнгер нар өөрсдийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, эрх зүйн мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх арга замын талаар санал солилцов.

Муж улсуудын шүүхийн Үндэсний төвийн Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Майкл Буэнгер олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах, танин мэдүүлэх хүрээнд хуульч бус мэргэжилтний оролцоог хангах, иргэдийн мэдээлэл авах сувгуудыг өргөнөөр ашиглахын чухлыг тэмдэглэсэн. Мөн уулзалтын төгсгөлд Нью Хэмпшир мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Гордон Макдональд хууль тогтоогч хууль тогтоомжийг батлахаас өмнө нийгэмд бий болгох үр нөлөөг сайтар ухамсарласан байх ёстойг онцолсон юм.




ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит
2023 оны эрдэм шинжилгээний
"ШИЛДЭГ БҮТЭЭЛ"
"ШИЛДЭГ ИЛТГЭЛ"
"ГРАНТ ОЛГОХ ТӨСӨЛ"
шалгаруулах уралдаан зарлагдлаа.
УДИРДАМЖ
Бүтээл хүлээн авах:
Илтгэл хүлээн авах:
Төсөл хүлээн авах:
Бүтээл, илтгэл, төслийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хүлээн авна.